

**МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ЗАСГИЙН  
ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН БОЛОН “МОНГОЛ  
УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ БАТЛАХ ТУХАЙ” МОНГОЛ  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ  
ЯВУУЛСАН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа**

Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нийгмийн бүлэгт чиглэсэн ямар төсөл, хөтөлбөрүүд хэрэгжээгүй талаар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өр, авлагын асуудлыг хэрхэн зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат хөдөө, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, Эрүүл мэндийн яамны зарлагдаагүй тендерийн санхүүжилтийг эргэн таталгүйгээр тендерийг дахин зарлах боломжтой эсэх, Эрүүл мэндийн болон Нийгмийн даатгалын сангийн нэр бүхий банкнаас авах авлагыг барагдуулах ажлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа “Хавдар судлалын үндэсний төв-2” төслийн хэрэгжилтийн явц, Эрүүл мэндийн болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны тоног төхөөрөмжийн санхүүжилтийг хассан талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ төрийн аудитын байгууллагаас төсвийн өрөнхийлөн захирагч нарт өгсөн алдаа, зөрчлийг засах зөвлөмжийн хэрэгжилт, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нөхцөлд авах арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчуулун Бүгд Найрамдах Солонгос Улс болон Япон улсад үйл ажиллагаагаа явуулж буй Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар татан буугдсан эсэх, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын үйл ажиллагааны талаар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн хөрөнгө, үйл ажиллагааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа аудитын байгууллагаас өгч буй

зөрчилтэй, хязгаарлалтай, зөрчилгүй гэсэн дүгнэлтийн талаар, эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын салбарын нийт 29 төсөл, арга хэмжээнүүд яагаад хэрэгжээгүй, гүйцэтгэл байхгүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен Эрүүл мэндийн даатгалын сангийн өр, авлагыг хэрхэн барагдуулах, Баян-Өлгий аймгийн эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн худалдан авалтын гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах албаны төсвийн гүйцэтгэл 10 хувь, Эрүүл мэндийг дэмжих сангийн төсвийн гүйцэтгэл 50 хувьтай байгаа шалтгааны талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоон судалгаа, мэдээллийг нэгдсэн байдлаар гаргах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа зураг төсөл нь батлагдаагүй ямар хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүд 2024 оны төсөвт хууль зөрчиж тусгагдаад хэрэгжээгүй талаар, Б.Бейсен эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилтийн хүрээнд эмнэлгийн тусlamж, үйлчилгээ доголдож байгааг анхаарах талаар саналаа хэллээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2-т заасны дагуу Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлж байна.

Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсандаа баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Л.ЭНХНАСАН

